



**МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ**

2009 оны 09 сарын 10 өдөр

Дугаар 328

Улаанбаатар хот

**Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр
гадаадад сургах тухай**

Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 177 дугаар тогтоолоор батлагдсан “Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх журам”-ыг үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын захиалгаар Сандаг овогтой Алтантунгалагийг Америкын Нэгдсэн Улсын Колорадогийн их сургуулийн магистрантурт эдийн засгийн чиглэлээр 2 жилийн хугацаатайгаар Сургалтын төрийн сангийн зээлээр суралцуулсугай.

2. Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 177 дугаар тогтоолоор батлагдсан “Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх журам”-ын дагуу суралцагчтай гэрээ байгуулж, суралцах сургуулийн нь нэхэмжлэлийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Д.Нансалмаа/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн боловсролын газар/М.Баасанжав/-т тус тус даалгасугай.



Ё.ОТГОНБАЯР